



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 80

Мандалговь

┌ Үл хөдлөх хөрөнгөнд үнэлгээ тогтоож, ┐  
худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 10,980,384 /арван сая есөн зуун наян мянга гурван зуун наян дөрөв/ төгрөгийн балансын үнэтэй, 4,463,110 /дөрвөн сая дөрвөн зуун жаран гурван мянга нэг зуун арав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Буянт багийн хичээлийн байрыг худалдах доод үнийг 3,600,000 /гурван сая зургаан зуун мянга/ төгрөгөөр, Буянт багийн гал тогоог худалдах доод үнийг 960,000 /есөн зуун жаран мянга/ төгрөгөөр тогтоон дуудлага худалдаанд оруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (М.Болормаа)-д даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 16 дугаар сарын  
30-ний өдрийн 80 тогтоолын хавсралт

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дуудлага худалдаанд худалдах барилгын мэдээлэл

№	Барилга, байгууламжийн нэр	зориулалт	Хэмжих нэгж		Ашиглалтад орсон огноо	Ашиглалтын хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөг	Дуудлага худалдааны үнэ
			Хэмжих нэгж	Биет хэмжээ						
1	Хичээлийн байр	Төрийн үйлчилгээний алба	М2	60	1980.09.01	60	9,328,800	5,739,803	3,511,256	3,600,000
2	Гал тогоо	Төрийн үйлчилгээний алба	М2	20	1980.09.01	60	1,651,584	685,866	951,854	960,000
<b>Нийт дүн</b>										
							<b>10,980,384</b>	<b>6,425,669</b>	<b>4,463,110</b>	<b>4,560,000</b>
							<b>/арван сая эсон зуун наян мянга гурван зуун наян дөрөв/ төгрөг</b>	<b>/зургаан сая дөрвөн зуун харин таван мянга зургаан зуун жаран ес/төгрөг</b>	<b>/дөрвөн сая дөрвөн зуун жаран гурван мянга нэг зуун арав/ төгрөг</b>	<b>дөрвөн сая таван зуун жаран мянган төгрөг/</b>